

**ОУВС-гийн Захирлуудын зөвлөл Монгол Улсад хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дөрөвдүгээр шатны үнэлгээг хянаж, 36.91 сая ам. долларын санхүүжилтийг баталлаа**

- Хөтөлбөр хэрэгжиж эхэлсээр 1 жилийн хугацаа өнгөрөөд байгаа ба төсвийн болоод гадаад валютын нөөц дээрх гүйцэтгэлүүд зорилтоос давж биелэхийн хамт Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд хүчтэй хэвээр байна.
- Төсвийн бодлого, банкны салбарыг бэхжүүлэх бүтцийн өөрчлөлтүүд үргэлжилсээр байгаа ч хэрэгжилтийн явцад зарим хоцрогдол үүссэн.
- Өрийн хэмжээ өндөр хэвээр, эдийн засаг дэлхийн түүхий эдийн зах зээлийн өөрчлөлтөд шууд өртөгдөх эрсдэл байгаа учраас эрх баригчид хөтөлбөрийн хүрээнд тохирсон үүрэг амлалтуудаа тууштай хэрэгжүүлэх нь чухал байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Захирлуудын зөвлөл гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ)-ийн хэрэгжилтийн дөрөвдүгээр үнэлгээг 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцэж баталлаа. Энэхүү үнэлгээг хийж дуусгаснаар, Монгол Улс 26.2088 сая ЗТЭ буюу ойролцоогоор 36.91 сая ам. долларын санхүүжилт нэмж авах боломжтой болох бөгөөд ингэснээр, энэ хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 131.0366 сая ЗТЭ буюу 184.55 сая ам. долларын санхүүжилт олгогдож байна.

Хөтөлбөр батлагдсанаас хойшхи хэрэгжилт сайн байгаа. Бодлогын хэрэгжилт тууштай, гадаад орчин таатай байсны үр дүнд эрх баригчид хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 03-р сарын эцэст тавьсан бүх зорилтот тоон үзүүлэлтүүдийг давуулан биелүүлж чадсан. Бүтцийн шинэчлэлийн хүрээнд ахиц гарсан ч гэсэн зарим талаар хоцрогдолтой байгаа.

Монгол Улсад хэрэгжүүлж буй гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр нь 2017 оны 5 дугаар сарын 24-нд батлагдсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 сая ЗТЭ буюу ойролцоогоор 434.3 сая ам. долларын санхүүжилт олгогдох юм ([Хэвлэлийн мэдээлэл No. 17/193](#)-ийг үзнэ үү). ОУВС-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжих Засгийн газрын “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” нь эдийн засгийг тогтворжуулах, төсвийн алдагдал, өрийн хэмжээг бууруулах, гадаад валютын нөөцийг нөхөн бүрдүүлэх, тэлэлт-агшилтын мөчлөгийг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээг нэвтрүүлэх болон тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг дэмжих зорилготой юм.

ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр хөтөлбөрийн үнэлгээг хэлэлцсэний дараагаар хурлын даргын үүрэг гүйцэтгэгч бөгөөд тус сангийн дэд тэргүүн ноён Тао Чжан дараах мэдэгдлийг хийв. Үүнд:

“ОУВС-гийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад хэрэгжиж буй хөтөлбөр эерэг үр дүнтэй байна. Хөтөлбөрийн хэрэгжилт сайн, гадаад эрэлт өндөр байсны үр дүнд эдийн засаг

эрчимтэй сэргэж байна. Түүнчлэн төсвийн тогтвортой байдал, өрийн динамик нэмэгдэхэд болон гадаад эрсдэл буурахад дорвитой ахиц гарлаа.

“Энэ хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 3-р сарын эцэст тавьсан бүх зорилтот тоон шалгуур үзүүлэлтүүд хангагдсан. Төсвийн гүйцэтгэл ихээхэн сайжирч, төсвийн орлого огцом нэмэгдсэнээр, эхний гүйцэтгэлээр төсөв ашигтай гарсан байна. Мөн үүнтэй зэрэгцэн гадаад валютын нөөц хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш хоёр дахин өсчээ.

“Банкуудын активын чанарын нарийвчилсан үнэлгээ 1-р сард эцэслэсэн бөгөөд санхүүгийн салбарыг бэхжүүлэх реформын хүрээнд дараагийн арга хэмжээнүүд авч эхлээд байна. Банкууд дутагдсан өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, нөхөхөөр ажиллаж байгаа. Цаашлаад эрх баригчид банкны салбарын тогтвортой байдлыг хангахын тулд хэрхэн нийтийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах талаар тодорхой заасан хуулийн төслийг баталсан.

“Эдгээр ахицтай үр дүн гарсан ч, Монгол Улс гадаад болон дотоод шокуудад мэдрэг хэвээр байна. Эдийн засгийн энэхүү таатай нөхцөл байдлыг ашиглаж, банкны салбарыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчны бүрдүүлэх, төсвийн алдагдлыг бууруулан гадаад валютын нөөцийг үргэлжлүүлж нэмэгдүүлэх зэрэг нь зайлшгүй хийх ёстой ажлууд юм. Эрх баригчдын шинэчлэлийн хөтөлбөрийг тогтвортой бөгөөд эрчтэйгээр хэрэгжүүлснээр үүсч болзошгүй шокын эсрэг эсэргүүцлийг бий болгож, тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг үргэлжлүүлэн хангаж чадна.”